

МОНГОЛБАНК-нд

Ариг банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнийн ажлын тайлан

2023 оны 04 дүгээр улирал

2023 оны 12 дугаар
сарын 28-ны өдөрУлаанбаатар
хот

Миний бие П.Мөнх-Эрдэнэ нь “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/-ийн хараат бус гишүүн, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх хорооны гишүүнээр өнгөрсөн хугацаанд ажиллаа.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн ээлжит, ээлжит бус хуралд оролцож холбогдох хурлыг удирдаж, тогтоолын төсөл, шийдвэр, дүгнэлт, асуудалд саналаа өгч ажилласан. Хүснэгтээр харуулбал:

Хуралд оролцсон байдлаар №1:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Цалин урамшууллын хорооны хурал	Засаглал нэр дэвшүүлэх хорооны хурал	Нийт оролцсон хурал
1.	-	6	1	-	7

Дээрх хугацаанд ТУЗ-ийн даргын хувьд Ариг Банкны 2023 оны 03 дугаар улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн, мөн банкны “Нягтлан бодох бүртгэлийн бодлого” шинэчлэн баталсан. Үүнээс гадна Монголбанкны А-1а/999 тоот албан бичгийг хүргүүлэх тухай албан тоотыг банкны хувьцаа эзэмшигч болох Улаанбаатар Импэкс ХХК болон Дэм санхүүгийн нэгдэл ХХК-д тус тус хүргүүлсэн.

Монголбанкны тушаалын биелэлтийг хүргүүлэх тухай 2023-03-27 өдрийн Н/08 тоотод хариу хүргүүлсэн.

2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн НБД/23/30 тоот албан бичгээр хувьцаа эзэмшигч Улаанбаатар Импэкс ХХК-д Зохистой засаглалын журмын талаарх бодлогын баримт бичгийг хүргүүлж шаардлагатай баримт бичгийг боловсруулахыг хүссэн.

Хурал хуралдсан огноогоор №2:

№	Хувьцаа эзэмшигчдийн хурал	ТУЗ-ийн хурал	Цалин урамшууллын хорооны хурал	Засаглал нэр дэвшүүлэх хорооны хурал
1.	-	2023-10-24 2023-10-30 2023-11-03 2023-12-04 2023-12-14 2023-12-25	2023-12-20	

Энэхүү хуралдаанаас гадна ТУЗ-р хэлэлцэгдэн батлах ёстой “Хүний нөөцийн бодлого”, “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого” зэргийг холбогдох хороогоор урьдчилан хэлэлцүүлсэн.

Урьдчилсан хэлэлцүүлгийн дагуу дээрх 2 бодлогод нэмэлт сайжруулалт, өөрчлөлт, найруулга оруулах зөвлөмжийг өгч ажиллаа.

Хараат бус гишүүнээр хуралд заавал санал өгсөн байдлаар №3:

№	Сонирхлын зөрчилтэй асуудал	Их хэмжээний хэлцэлтэй холбоотой асуудал
1.	6	1

Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй 6 хэлцэл болон Их хэмжээний 1 асуудалд оролцож, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтад оролцсон бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

ТУЗ-ийн дарга, гишүүний хувьд:

1. 6 сонирхлын зөрчилтэй хэлцлийн 1 хэлцэл нь өмнө нь ТУЗ-р шийдвэрлэсэн хэлцэл байсан. Номин Их дэлгүүрт банкны салбар, тооцооны нэгж байгуулахтай холбоотой ашиглалтын хэмжээнд өөрчлөлт орсон тул дахин ТУЗ-р шийдвэрлүүлсэн. Гэрээний байршил болон төлбөрийн нөхцөлд ямарваа нэгэн давуу байдал үүсээгүй.
2. Мөн Номин даатгал ХХК-тай ажилчдын болон банкны үл хөдлөх, хөрөнгийг даатгах гэрээг дахин нэг жилээр сунгасан. Сунгахдаа ижил төрлийн үйлчилгээ эрхэлдэг 4-5 даатгалын компанитай харьцуулан шийдвэр гаргасан.
3. Үлдсэн 5 сонирхлын зөрчилтэй байж болох асуудал нь хувьцаа эзэмшигч Улаанбаатар Импэкс ХХК, түүний хувь эзэмшигч, тэдгээрийн эцсийн өмчлөгчтэй холбоотой гэж үзсэн учраас уг асуудлыг ТУЗ-ийн хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй этгээдүүд санал өгсөн. Ийнхүү 3 хараат бус гишүүн 100% санал нэгтгэж Номин Трейдинг ХХК-ийн Номин Моторс, Флай эдвэнчурс ХХК, Опен Адвенчурс ХХК -тай зээлийн бүтээгдэхүүнээр хамтран ажиллах гэрээ байгуулах, хавсралтад дурдсан нөхцөлийн дагуу гэрээ байгуулах эрхийг банкны Гүйцэтгэх захиралд олгов. Гэрээний нөхцөл нь ямар нэг давуу байдал огт олгоогүй, судалгаатай, нөхцөл байсныг энд дурдах нь зүйтэй.
4. Их хэмжээний хэлцэлд Гүйцэтгэх захирлын эрх мэдэл хэдий байсан ч гэсэн Монгол Улсын Засгийн газрын бонд барьцаалах анхны тохиолдол учраас ТУЗ-р баталгаажуулахаар хэлэлцүүлсэн. ТУЗ-ийн бүх гишүүд зөвшөөрсөн. Уг хэлцэл хийгдээд 7 хоногт бүрэн хэрэгжиж хаагдсан. Энэ үйл явцад хараат бус гишүүний хувьд байнгын хяналт тавьж ажилласан болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүний хувьд:

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчил үүсэж болзошгүй 6 удаагийн хэлцэлд саналаа өгсөн. Санал өгөөгүй хэлцэл байхгүй.

1. Холбоотой этгээдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах 6 тохиолдол тус тус байна. Үүнд:
 - a. Номин Их дэлгүүрт салбар байгуулах буюу талбайн хэмжээг өөрчлөгдсөн,
 - b. Номин даатгал ХХК-тай байгуулсан гэрээг дахин 1 жилээр сунгах,
 - c. Номин Моторс автомашин худалдан борлуулах буюу гэрээг дахин 1 жилээр сунгах,
 - d. Флай эдвэнчурс ХХК-аас автомашин худалдан авч буй харилцагч нарт олгох зээлийн нөхцөлийг батлах,
 - e. Опен Адвенчурс ХХК-ийн ажилтнуудад олгох зээлийн бүтээгдэхүүний нөхцөлийг батлах,
 - f. Опен Адвенчурс ХХК-тай банкны зээлийн ерөнхий нөхцөлийн дагуу “Хэрэглээний худалдан авалтын зээл” бүтээгдэхүүнээр хамтран ажиллах зэрэг болно.

Дээрх хэлцлүүд бүгд харьцуулсан судалгаатай ба сонирхлын зөрчилгүй гишүүд 100%-ийн саналтайгаар шийдвэрлэсэн.

ТУЗ-н хараат бус гишүүний хувьд дараах зарчим, зорилтуудад Банк анхаарлаа хандуулж байгааг онцлон хэлмээр байна.

- ТУЗ-н үйл ажиллагаа нь бодлого боловсруулагчаас гаргасан хууль тогтоомжийн дагуу явагддаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг дэгийн дагуу, хүчин төгөлдөрт тооцогдох эсэхэд анхаарч ажилдаг.
- Монголбанкнаас ирүүлсэн мэдэгдлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлж эргэн тайлагнадаг,
- ТУЗ-с засаж залруулах боломжтой асуудлууд байгаа тохиолдолд бид ТУЗ-н түвшинд хэлэлцүүлгийг эхлүүлж, үйл ажиллагааг хэрхэн сайжруулах талаар удирдамж өгч, эргэн тайлагнах хугацааг өгдөг. Удирдлагын баг эдгээр хүсэлтийг дагаж мөрдөж, шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь авдаг.
- Тайлангийн хугацаанд Банкны хараат бус гишүүний хувьд банканд сөргөөр нөлөөлөхүйц буруу зүйл илрүүлээгүй тул ямар нэгэн тодорхой асуудлаар ээлжит бус хурал зарлах шаардлага гаргаагүй.
- ТУЗ нь гаргасан шийдвэр, үндэслэлийн талаар ил тод байж, цаг тухайд нь мэдээлдэг.
- ТУЗ-ийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй бөгөөд хэрэв надад асуулт байгаа эсвэл нэмэлт тодруулга авах шаардлагатай бол ТУЗ болон Удирдлагын багаас зохих мэдээллийг авдаг.
- Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.
- Тайлангийн хугацаанд ТУЗ-с гаргасан бүх шийдвэрийг санал хураалтад миний зүгээс сайтар судалж, дэмжсэн болохыг үүгээр баталж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу ажлын тайлангаа тайлагнав.

ТУЗ-ийн гишүүд болон түүний дэргэдэх хороодын зүгээс засаглалын тогтолцоог сайжруулах, хувьцаа эзэмшигчид болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, эрх тэгш байдлыг хангах, МУ-д мөрдөгдөж буй хууль, журамд үйл ажиллагаагаа нийцүүлэн ажиллаж байна.

Мөн банкны ТУЗ-ийн гишүүдийг чадавхжуулахаар сургалт зохион байгуулахаар ажиллаж холбогдох үүрэг даалгаврыг өгсөн.

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Банкны дүрэмд заасан хараат бус гишүүний эрх, үүргээ хэрэгжүүлэн бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг барьж ажиллахыг чармайж ирсэн болно.

Тайлан бичсэн:

Ариг банкны ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн,

Засаглал нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн

П.Мөнх-Эрдэнэ